БАТЛАВ

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН

ДАРГА Г.ВАНДАНДОРЖ

“ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 4, 5, 6, 7, 10, 16, 23, 24 ДҮГЭЭР ХОРОО, ЯАРМАГ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАРИГДАЖ АШИГЛАЛТАД ОРСОН ХОТХОНУУДАД ХЭРЭГЛЭГДЭЖ БУЙ ЦЭВЭР УСНЫ ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛТ” АЖЛЫН ЗУРАГ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024 оны 02-р сарын 28 Дугаар 01 Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	1.1.	- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 сарын 05-ны өдрийн №122 дугаар “Нийслэлийн 2024 оны төсөв батлах тухай” тогтоолийн Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалт 75.1 дүгээр заалт
2.	Байршил	2.1	*Хан-Уул дүүргийн 4, 5, 6, 7, 10, 16, 23, 24 дүгээр хороо*
3.	Обьектын бүрэлдэхүүн, хүчин чадал,	3.1.	- Цэвэр усны ф225мм голчтой PN16 даралтын шугам - Цэвэр усны ф355мм голчтой PN16 даралтын шугам - Даралт бууруулах хаалт ф300мм (шаардлагатай цэгт) - Даралт бууруулах хаалт ф200мм (шаардлагатай цэгт)
4.	Зураг төсөл боловсруулах үе шат	4.1	**1 үе шаттай** - **I үе шат:** Ажлын зураг төсөл, төсөв
5.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	5.1 5.2	**Монгол Улсын хуулиуд:** - Хот байгуулалтын тухай хууль; - Барилгын тухай хууль; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Усны тухай хууль; - Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд **Норм, нормативууд:** - “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” (БНбД 30-01-04); - Геодезийн байнгын цэг тэмдэгт байгуулах ажил БД 11-104-06; - Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсэн заавар (УББ 30-201-09); - “Хот байгуулалтын кадастр” (БД 14-102-09); - Усны барилга байгууламжийн буурь БНбД 33-04-09; - Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл БНбД 33-05-09; - Шороон боомт БНбД33-07-09; - Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон БНбД 33-04-09; - Цутгамал бетон, төмөрбетон бүтээц БНбД 52-02-05;

			- Ган бүтээц БНбД 53-02-05; - Төмөр зам ба авто замын тоннель БНбД 32-05-07; - Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-16; - Барилга доторх ус хангамж, ариутгах татуургаБНбД 40-05-16; - Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа БД 11-102-07; - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09; - Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл БНбД 11-07-19; - Газар зүйн мэдээлэл. Инженер-геологийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт MNS 6925-9 : 2021; - "1:500, 1:1000, 1:2000, 1:5000-ны масштабтай байр зүйн зураглалын ажил" БНбД 11-106-08; - MNS 0900:2018 "Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ" **Холбогдох журмууд:**
		5.3	- Монгол улсын Засгийн газрын 2019 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 108 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах магадлал хийх дүрэм" - Бусад холбогдох норм, дүрэм, заавар
6	Зураг төслийн бүрдэл	6.1. 6.1.2 6.1.3 6.1.4 6.1.5 6.2 6.2.1 6.2.2 6.2.3 6.2.3	**I үе шат:** - Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга) - "Барилгын зураг төслийн ASELTA ХХК"-ны гүйцэтгэсэн ажлын зургийн трасс болон шинэчилсэн трассыг ажлын зурагт тусгана. - Ажлын талбайд бусад инженерийн шугам сүлжээг шилжүүлэх, хамгаалах техникийн шийдлийн зураг төсөл - Урьдчилсан хөрөнгө оруулалтын тооцоо - Одоо байгаа орон сууцны хотхонуудын салаа шугамын холболтуудын материал зардлыг тооцож тусгах **II үе шат:** - Шинэчилсэн шугам сүлжээний ажлын зураг : - Нэгдсэн төсөв. Зураг төсөл 3 хувь. Үүнээс, график зураглалыг CD-ний хамт захиалагч болон хангагч байгууллагад, үлдсэн хувийг архивд өгнө. Инженерийн шугам сүлжээний техникийн болон ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан зургийг CD-ээр Хот байгуулалт хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс, Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд хүргүүлэх, Ажлын зурагт бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийг нэг дэвсгэр дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх.

7.	Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийцэд тавигдах шаардлага	7.1 7.1.1 7.1.2	- Төвийн цэвэр усны дамжуулах шугамнаас холбогдож байгаа дамжуулах шугамын холболт, салбар шугамыг бүрэн оруулах - Цэвэр усны шугамын материалыг PE өндөр даралтын цэвэр усны хоолой MNS ISO 4427:2007 стандарт болон бусад стандартын шаардлага хангасан байхаар тооцох - Зайлшгүй шаардлагаар (авто зам доогуур г.м) ган шугам төлөвлөх тохиолдолд цайрдсан ган хоолойн стандартаар материал сонгох.
8.	Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага	8.1	- Шинээр төлөвлөж буй шугамыг тухайн орчинд төлөвлөгдсөн бусад инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөлтэй уялдуулах.
9.	Эдийн засгийн тооцоо, төсөв	9.1 9.1.1 9.1.2 9.1.3	**I үе шат:** Ажлын зургийн дагуу хөрөнгө оруулалтын тооцоо - Эдийн засгийн тооцоог УББ 80-204-16 “Хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцох заавар”-аар, төсвийг БНбД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно. - Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 217 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Барилгын дүрэм батлах тухай”, 2 дугаар хавсралтаар батлагдсан "Барилгын ажилтны цагийн тарифт цалингийн жишгийг индексжүүлэн хэрэглэх аргачлал"-тус тус баримтлах - Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан төсвийг үе шаттайгаар тооцох - Одоо байгаа авто зам, замын хөндлөн гарах гаргалгааны хэсэгт мэргэжлийн байгууллагаас тавьсан шаардлагыг нарийвчлан тусгаж, нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгана..
10.	Зураг төсөл боловсруулах байгууллага		Ажлын зураг боловсруулах ажил: Зөвлөх үйлчилгээний 1.2.6, эсвэл , 3Т-3.4, 4.4, 5.4, 10.2 заалттай эрх бүхий хуулийн этгээд
11.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл		- Байгаль орчны үнэлгээ шаардлагагүй. - Одоо байгаа шугам сүлжээний трассыг ашиглан угсралт хийгдэнэ.
12.	Зураг төслийн санхүүжилт		Нийслэлийн төсөв
13.	Төслийн захиалагч		Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
14.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас	14.1. 14.2.	Шугам сүлжээний угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. Шугам сүлжээг зөөж шилжүүлэх тохиолдолд трассын сонголтыг бусад инженерийн шугам сүлжээтэй холбогдох нормын дагуу уялдуулан, газар чөлөөлөлт хамгийн бага байх хувилбарыг сонгон холбогдох байгууллагуудтай зөвшилцөх.

	нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	14.4.	Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулах.
		14.5	Ажлын зураг төсөлд одоо байгаа авто зам, явган зам, гүүр, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн байгууламжийн сэргээн засварлах, тохижуулах ажлын зардлыг холбогдох дүрэм журам, үнэлгээний дагуу тооцон төсөвт тусгах
			Газар доорх болон дээрх бусад инженерийн байгууламжтай огтлолцох, давхцах тохиолдол бүрд шаардлагатай нэмэлт арга хэмжээ авахад гарах зардлыг ажлын зураг, хяналтын төсөвт тусгах.
		14.6	Ажлын зураг боловсруулахад шугам сүлжээний хангагч байгууллагаас одоо байгаа шугам, худаг, тоноглолын архивын зураг төслийг зөвлөх үйлчилгээний байгууллагад хүргүүлэх.

ЗӨВШӨӨРСӨН:

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

Ж.ДАГВАСҮРЭН

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ИНЖЕНЕРИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ОДХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН УС ХАНГАМЖИЙН ИНЖЕНЕР

Р. АТАРЖАРГАЛ